



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/05



ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27-28
Зургаа. Төсөв, санхүү	29-30
Долоо. Үнэ.....	31-34
Найм. Хөдөө аж ахуй	35-37
Ес. Аж үйлдвэр.....	38-42
Арав. Байгаль орчин	43

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 05 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 05 сард 599 эх амаржиж, 602 хүүхэд шинээр мэндэлж, 142 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 17(2.9%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 17(28%)-оор, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 5(3.6%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 460 болж 2020 оны мөн үеийнхээс 12(2.7%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 8.4, нас баралт 2.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.1 пунктээр, нас баралт 0.1 пунктээр тус тус өссөн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 05 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар буурчээ.



1.2 Эрүүл мэнд

2021 оны эхний 05 сарын байдлаар 203.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар, 5.2 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар тус тус өсч, 6.9 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар буурчээ.


2021 оны эхний 05 сард 756 эх жирэмсний хяналтанд орсны 99.2 хувь буюу 700 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд

хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага 7.5 мянган удаа гарсны 1.6 мянга буюу 21.3 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 14.38 хувиар буурч, алсын дуудлага өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 1028 хүн бэртэж, 21 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 155(13.1%)-аар буурч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 31.0 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 27.5 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 14.8 хувь, бусад төрлийн өвчин 12.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 6.3 хувь, хоол шингээх эрхтний өвчин 7.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 234 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 88-аар буюу 27.3 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад цусан суулга 81.5 хувиар, трихоминиаз 37.5 хувиар, сүрьеэ 27.3 хувиар, заг хүйтэн 26.9 хувиар, тэмбүү 20.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 05 сарын эцэст 283 болсны 232 (82.0%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 51 (18.0%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 185(39.5%) хүнээр буурч, өмнөх сараас 22 (8.4%) хүнээр өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 157(55.5%) нь бүрэн дунд, 65(23.0%) нь дээд, 26(9.2%) нь тусгай дунд, 13(4.6%) нь техник мэргэжлийн, 17(6.0%) нь бүрэн бус дунд, 3(1.1%) нь боловсролгүй, 2(0.7%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 05 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны эхний 05 сарын байдлаар бүртгэлтэй байсан 70 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 66 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 05 сарын байдлаар 21040.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4201.8 (25.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 05 сард өмнөх оны мөн үеэс 4201.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 4184.7 (39.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 54.9 (4.6%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 721.5 (25.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 05 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 25896.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 1528.5 (6.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 19421.2 (75.0%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3466.4 (13.4%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1438.9 (5.6%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1114.2 (4.3%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 456.1 (1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг





Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 05 сард нийгмийн халамжийн сангаас 10499 иргэнд 2156.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэд 9225 (46.8%)-оор, олгосон тэтгэвэр тэтгэмж 1310.2 (37.8%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн хамламжийн сангийн зарцуулалт буурсан нь 2020 оны 09-р сараас эхлэн цалинтай ээж хөтөлбөр, жирэмсэн эхийн тэтгэмж, алдарт эхийн одонгийн тусламж, насны хишиг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжүүд и-халамж цахим системд шилжиж ХХҮЕГ-аас шууд арилжааны банкуу шилжүүлэг хийгддэг болсонтой холбоотой юм.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 5 сард 1304 хүн хамрагдсан нь өмнөх оноос 8 (0.6%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 972.2 сая төгрөг болж 316.0 (24.5%) сая төгрөгөөр тус тус буурчээ.


Нийгмийн халамжийн тэтгэмж 1134 иргэнд 499.1 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1014 иргэнд 405.8 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангийн зардлыг 13 иргэнд 15.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 7034 иргэн хамрагдаж, 262.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны 05 дугаар сарын байдлаар 172 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 75 хүн гэмтэж, 3 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 4(2.3%)-өөр, нас барсан хүний тоо 1 (25.0%)-ээр тус тус буурч, гэмтсэн хүний тоо 29 (63.0%) – өөр өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 32 (2 дахин)-оор, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8 (2.3 дахин)-аар, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 2 (3 дахин)-оор олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 7 (8 дахин)-оор тус тус өсч, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 8(88.8%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5(55.6%)-аар, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1(33.3%)-ээр, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 29(29.9%)-өөр, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(25.0%)-ээр тус тус буурч, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 39.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 36.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.1 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4.7 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 2.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 8.8 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 39 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9(30.0%)-өөр нэмэгдсэн байна.



Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Мандах, Өргөн, Хатанбулаг, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Улаанбадрах, Хөвсгөл сумдад өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 208.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 342.0 (62.1%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 109.7 (52.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 77(44.8%) нь гэр орон сууцандаа, 39(22.7%) нь согтуугаар, 23(13.4%) нь гудамж олон нийтийн газарт, 11(6.4%) бүлэглэн, 14(8.1%) хувийг эмэгтэй хүн оролцон, 59(34.3%) нь өдрийн цагаар /14-19 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 515 хүн саатуулагдаж, 77 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 05 сард



Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк


Монгол банкны 5-р сарын мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 33.7 мянга болж өмнөх оноос 1.5(4.3%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 79.7 мянга болж өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар өссөн байна.

Ипотекийн нийт зээлдэгчийн тоо 99 болж өмнөх оны мөн үеэс 63(2.7²) өсч, нийт 5371.7 сая төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 3827.9(3.4²) өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020-2021 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 197.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2481.6 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дунджаар 2770.1

мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.8(47.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 7.6 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.5(6.4%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 2469.7(24.5 %) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 12.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.2(1.1%)сая төгрөгөөр өсж, өмнөх оны мөн үеэс 1927.8(17.8%) сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2021.05 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.5 сард






2.2 Төсөв, санхүү

2021 оны 05 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 15099.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 80.1 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 4.3 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 74.7 хувийг татварын, 25.3 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 05 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 3841.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 13.2 хувь буюу 581.9 сая.төг-өөр дутуу, төлөвлөгөөнөөс 10.7 хувь буюу 372.2 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 05 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар тус тус өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 3.5 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 0.7 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.5 хувь, тээврийн бүлэг 0.1 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.8 хувь, тээврийн бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.2 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 1.4 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 4.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.5 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 7.0 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 9.8 хувь, тээврийн бүлэг 0.5 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 6.5 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 3.1 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 05 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 -2021 оны 05 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1083.4 мянган хээлтэгч малын 648.1 мянга (59.8%) нь 2021 оны эхний 05 сард төллөсөн байна. Эм хонины 69.8 хувь, эм ямааны 57.2 хувь, ингэний 35.8 хувь, үнээний 30.7 хувь, гүүний 25.8 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.0 хувь буюу 636.8 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 45.7 (6.7%) мянгаар бага байна. Дэлгэрэх суманд 68.7 мянга, Хатанбулаг 67.2, Иххэт суманд 63.7 мянга, Алтанширээ суманд 61.1 мянга, Даланжаргалан суманд 55.2 мянга, Айраг суманд 47.2 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 57.0 хувийг эзэлж байна.


Том малын зүй бус хорогдол 2021 оны 05 сард аймгийн хэмжээнд 26234 болж, өмнөх оны мөн үеэс 25505 (35 дахин) толгойгоор илүү байна. Нийт хорогдсон малын 54.0 хувийг ямаа, 37.2 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 05 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Алтанширээ суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Эрдэнэ суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Дэлгэрэх суманд их буюу 1600.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Сайхандулаан, Хөвсгөл, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 250.0 мянган төгрөг, Улаанбадрах суманд хамгийн бага буюу 150.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Айраг, Хөвсгөл сумдад хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Улаанбадрах суманд хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.

Зураг. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 05 сард, мянган төгрөгөөр



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 05 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 100694.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 232283.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 48377.2 сая төгрөгөөр буюу 92.5 хувиар, нийт борлуулалт 137940.0 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

2021 оны 05 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 92.5 хувиар өсөхөд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 40648.1 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 6818.9 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5.3 хувийг төрийн, 95.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 5.3 хувь, компани 94.1 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.



Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ус түгээлт 18.5 мян.м3-аар, сувагжуулалт 37.7 мян.м3-аар, савласан цэвэр ус 586.7 мян.литрээр, бялуу 1.0 тонноор, хиам 11.7 тонноор, хэрчсэн гурил 4.6 мян.тонноор, банш, бууз 0.7 тонноор, гутал 54 ширхгээр, нүүрс 607.4 мян.тонноор, шохой 2300 тонноор, цемент 80.3 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 5 дугаар сарын дундаж агаарын температур нийт нутгаар 10.7 – 15.0 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 29 - 33 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Улаан-Уул, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын нутгаар ОЖДундаж орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас хүйтэн байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 3.0 – 6.0 градус хүйтэн, өдөртөө нийт нутгаар 50 - 57 градус дулаан байв.

Хур тунадас: Энэ сард нийт нутгаар бороо 2 - 8 өдөр бороотой байлаа. Замын-Үүд суманд 19.0 мм, Иххэт суманд 15.8 мм, бусад сумдын нутгаар 1.0 – 9.8 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Замын-Үүд, Мандах, Дэлгэрэх, Айраг, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Улаанбадрах сумдад ОЖД-аас ахиу, Хөвсгөл, Сайхандулаан сумдад ОЖД-аас бага, Эрдэнэ суманд ОЖДундаж орчим бороо орсон байна.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Иххэт суманд 16 м/с, бусад сумдын нутгаар 20 – 30 м/с хүрч, **хүчтэй шороон шуурга шуурч цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдлаа.** 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд, Замын-Үүд, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад 22 – 24 өдөр, бусад сумдад 10 - 19 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: Энэ 10 хоногын байдлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр Замын-Үүд суманд 9 см, бусад сумдын нутгаар 2 – 6 см байлаа. Нийт сумдын нутгаар бэлчээрийн ургамал төлөгчдүү боролз, таана, хялгана, агь, зүүнгарын хазаар өвс гэм мэт төлөөлөх ургамлууд цухуйсан, Хөвсгөл сумын нутгаар бэлчээрийн төлөөлөх ургамал цухуйгаагүй байна.

МАН-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Малд нэмэгдэл тэжээл өгөх, тарилга хийх, туулга өгөх үйл ажиллагаа явагдаж байна. Нийт нутгаар малын усан хангамж дунд зэрэг / малыг холоос тууж усалж байгаагаас зутрах, хэт олон мал нэг дор бөөгнөрөх / байна.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2021 ОНЫ 05 ДУГААР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	69.6	69.9	71.2	71.7	100.6
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	565	522	585	602	102.9
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	160	167	137	142	103.6
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	405	355	448	460	102.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	3	8	4	50.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	1.8	5.7	13.7	6.6	48.6
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	860	885	468	283	60.5
- Үүнээс эмэгтэй	тоо	408	443	224	124	55.4
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	20	204	109	65	59.8
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	92	3	88	68	77.3
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	65	2	85	58	68.2
Улирлын чанартай ажлын байр	тоо	27	1	3	2	66.7
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	306	407	322	234	72.7
- 10000 хүнд ногдох	тоо	44	58	45	33	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	251	242	176	172	97.7
- 10000 хүнд ногдох ***	тоо	58	54	40	40	
6.Бойжиж буй төл	толгой	540011	644608	682569	636832	93.3
- Унага	толгой	12312	11046	14351	14034	97.8
- Тугал	толгой	11291	9182	15058	12442	82.6
- Ботго	толгой	5834	6272	6854	6487	94.6
- Хурга	толгой	274539	331397	347467	330313	95.1
- Ишиг	толгой	236035	286711	298839	273556	91.5
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	79542.4	71966.6	52316.8	100694.0	192.5
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	112477.0	126852.3	94313.2	232283.1	246.3

* - 2018,2019,2020 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 I-V	2021 I-V	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	171.0	203.5	32.5	119.0
2. Ор хоног	мян.хүн	54.4	49.6	-4.8	91.2
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	5.1	5.2	0.1	102.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	7.8	6.9	-0.9	88.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	8.8	7.5	-1.3	85.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.6	1.6	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1183	1028	-155	86.9
Үүнээс: нас баралт	хүн	21	21	0	100.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	773	756	-17	97.8
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	706	700	-6	99.2
8. Амаржсан эх	хүн	582	599	17	102.9
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	2	2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	8	4	-4	50.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 05 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насанд аа эндсэн хүүхэд	
Тоо					
Дүн	599	0	602	4	2
Айраг	1		1		
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1		1		
Улаанбадрах					
Хатанбулаг	2		2		
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ					
Сайншанд	443		444	3	2
Замын - Үүд	149		151	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	322	234	-88	72.7
Вируст гепатит	3	0	-3	0.0
Сүрьеэ	33	24	-9	72.7
Тэмбүү	44	35	-9	79.5
Заг хүйтэн	93	68	-25	73.1
Трихоминиаз	40	25	-15	62.5
Цусан суулга	27	5	-22	18.5
Бусад	82	77	-5	93.9

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 05 сард

Боловсролын түвшингээр	2018 V	2019 V	2020 V	2021 V	2021 V 2018 V	2021 V 2020 V
	хүний тоо				хувь	
ДҮН	860	885	468	283	32.9	60.5
Үүнээс: Эмэгтэй	408	443	224	124	30.4	55.4
Магистр, доктор	1	2	1	2	200.0	0.0
Дээд боловсролтой	168	114	105	65	38.7	61.9
Тусгай дунд	43	36	53	26	60.5	49.1
Техник мэргэжлийн	55	37	29	13	23.6	44.8
Бүрэн дунд	515	596	224	157	30.5	70.1
Бүрэн бус дунд	52	67	44	17	32.7	38.6
Бага	6	13	3	0	0.0	0.0
Боловсролгүй	20	20	9	3	15.0	33.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 05 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2020 V	2021 V	2020 V	2021 V	2020 V	2021 V
ДҮН	468	283	161	175	756	514
Айраг	21	2	1	1	29	4
Алтанширээ	7	10	3	1	13	10
Даланжаргалан	4	5	0	0	6	3
Дэлгэрэх	2	1	0	0	8	1
Иххэт	6	0	0	0	10	0
Мандах	3	2	0	2	6	5
Өргөн	3	0	1	37	16	38
Сайхандулаан	10	1	2	0	6	1
Улаанбадрах	5	1	1	10	17	6
Хатанбулаг	13	8	29	29	41	37
Хөвсгөл	4	0	0	0	6	0
Эрдэнэ	24	19	5	5	44	29
Сайншанд	237	151	106	50	410	241
Замын - Үүд	129	83	13	40	144	139

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, жил бүрийн 05 сард

Салбарын ангилал	2020 I-V	2021 I-V
	Тоо	
Бүгд	383	232
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	7	0
Уул уурхай олборлох аж үйлдвэр	4	49
Боловсруулах үйлдвэрлэл	1	3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	17	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	1	4
Барилга	119	52
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	24	18
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	9	7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	7	1
Мэдээлэл, холбоо	0	0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	22	18
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	45	3
Боловсрол	23	7
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	26	7
Урлаг, үзвэр,тоглоом наадам	15	8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	61	49
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V
	Тоо	
Бүгд	383	232
Менежер	5	8
Мэргэжилтэн	101	52
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	29	24
Контор, үйлчилгээний ажилтан	15	9
Худалдаа, үйлчилгээний ажилтан	56	17
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	34	61
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	31	7
Энгийн ажил мэргэжил	65	52
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	47	2

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2020 I-V		2021 I-V	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	161	64	175	86
Менежер	1	1	7	5
Мэргэжилтэн	31	19	46	27
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	12	8	18	12
Контор, үйлчилгээний ажилтан	9	6	9	8
Худалдаа, үйлчилгээний ажилтан	32	18	13	11
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	19	7	36	11
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч,	19	0	7	0
Энгийн ажил мэргэжил	36	5	37	11
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	2	0	2	1

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2021 оны 05 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	Тоо				
Бүгд	68	30	58	2	8
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0				
Уул уурхай олборлолт	1	1		1	
Боловсруулах үйлдвэрлэл	3		3		
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	0				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0				
Барилга	3	1	3		
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	23	13	22	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	10	1	10		
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл	2	2	2		
Мэдээлэл холбоо	0				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2	1	2		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл	13	4	5		8
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	4	7		
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын	1	1	1		
Боловсрол	2	2	2		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0				
Урлаг үзвэр тоглоом наадам	1		1		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	2021 I-V 2020 I-V
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	16 838.9	21 040.7	125.0
Тэтгэврийн даатгалын сан	10585.7	14 770.4	139.5
Тэтгэмжийн даатгалын сан	1201.0	1 255.9	104.6
Эрүүл мэндийн даатгалын сан	2796.2	3 517.7	125.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1763	1 249.7	70.9
Ажилгүйдлийн даатгалын сан	493.0	247.0	50.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	24 368.3	25 896.8	106.3
Тэтгэврийн даатгалын сан	18005.4	19 421.2	107.9
Тэтгэмжийн даатгалын сан	1539.7	1 438.9	93.5
Эрүүл мэндийн даатгалын сан	2973.6	3 466.4	116.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1194.4	1 114.2	93.3
Ажилгүйдлийн даатгалын сан	655.2	456.1	69.6

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	2021 I-V 2020 I-V
	ХҮН		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	19809	19312	97.5
Албан журмаар даатгуулагчид	16546	16391	99.1
Аж ахуй нэгж, байгууллага	8650	8458	97.8
Төсөвт байгууллага	7896	7933	100.5
Сайн дураар даатгуулагчид	3263	2921	89.5
2. Тэтгэвэр авагчдын тоо	9055	9487	104.8
Өндөр насны тэтгэвэр	6593	6967	105.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1326	1401	105.7
Тэжээгчээ алдсаны	491	478	97.4
Цэргийн тэтгэвэр	475	497	104.6
ҮОМШӨ*-ний	170	144	84.7
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	18 998.7	19 785.8	104.1
Өндөр насны тэтгэвэр	13 270.3	14 602.7	110.0
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 106.1	2 292.5	108.9
Тэжээгчээ алдсаны	831.3	825.6	99.3
Цэргийн тэтгэвэр	1 596.6	1 694.2	106.1
ҮОМШӨ*-ний	1 194.4	370.8	31.0

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 I-V	2021 I-V	2021 I-V 2020 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	16838.9	21040.7	125.0
Айраг	263.3	305.2	115.9
Алтанширээ	117.2	140.9	120.2
Даланжаргалан	741.0	689.0	93.0
Дэлгэрэх	132.7	169.3	127.6
Иххэт	225.7	265.2	117.5
Мандах	125.8	158.2	125.8
Өргөн	328.4	521.0	158.6
Сайхандулаан	135.0	150.1	111.2
Улаанбадрах	141.7	179.4	126.6
Хатанбулаг	313.5	365.2	116.5
Хөвсгөл	136.0	164.1	120.7
Эрдэнэ	271.7	299.7	110.3
Сайншанд	9463.6	11994.7	126.7
Зүүнбаян баг	501.3	609	121.5
Замын-Үүд	3942	5029.7	127.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 I-V	2021 I-V	2021 I-V 2020 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	24368.3	25896.8	106.3
Айраг	1150.4	1201.8	104.5
Алтанширээ	447.3	481.4	107.6
Даланжаргалан	1042.6	1023.2	98.1
Дэлгэрэх	524.5	573.9	109.4
Иххэт	824.5	858.6	104.1
Мандах	520.9	554.9	106.5
Өргөн	750.1	804.7	107.3
Сайхандулаан	370.4	409.6	110.6
Улаанбадрах	515.8	592.2	114.8
Хатанбулаг	902.0	959.1	106.3
Хөвсгөл	450.5	477.9	106.1
Эрдэнэ	820.7	888.5	108.3
Сайншанд	10672.4	11417.1	107.0
Зүүнбаян баг	876.2	896.0	102.3
Замын-Үүд	4500.0	4757.9	105.7



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-V 2020 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-V 2020 I-V
	2020 I-V	2021 I-V		2020 I-V	2021 I-V	
	Тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	19724	10499	53.2	3466.4	2156.2	62.2
1. Халамжийн тэтгэвэр	1312	1304	99.4	1288.2	972.2	75.5
Ахмад настны тэтгэвэр	93	102	109.7	89.4	58.8	65.7
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	371	357	96.2	349.3	204.4	58.5
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	462	467	101.1	447.5	268.9	60.1
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	1.0	0.6	56.1
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	385	377	97.9	400.9	439.6	109.6
2 Халамжийн тэтгэмж	1069	1134	106.1	446.1	499.1	111.9
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	529	538	101.7	194.7	212.1	109.0
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	229	253	110.5	134.0	152.6	113.9
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	252	288	114.3	92.7	109.3	118.0
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	50	45	90.0	21.3	20.7	97.2
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	4	80.0	2.0	1.7	85.5
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	4	6	150.0	1.5	2.5	170.5
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-V 2020 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-V 2020 I-V
	2020 I-V	2021 I-V		2020 I-V	2021 I-V	
	тоо		хувь	сая төгрөг	хувь	
4. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	863	1014	117.5	264.7	405.8	153.3
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	232	255	109.9	225.9	357.5	158.2
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	631	759	120.3	38.8	48.3	124.5
5. Нийгмийн халамжийн сан	23	13	56.5	27.6	15.6	56.5
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	3	1	0.0	3.6	1.2	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	19	11	57.9	22.8	13.2	57.9
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		1			1.2	
